

БАТЛАВ.  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Р.МӨРГЭН

БАТЛАВ.  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ  
ТАЭРВЭЙН ДАРГА  
Н.ЦАГААНХҮҮ

ЗАМ /ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР  
2019 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2019 оны 01 дүгээр сарын 07

| №   | Бүтээгдэхүүний нэр төрөл   | Хугацаа   | Хамтран ажиллах байгууллага                                    |
|---|--|-----------|--|
| <b>А. Удирдлага зохион байгуулалтын талаар</b>      |  |           |  |
| 1   | Зам, тээврийн салбарын хуулиар эрх олгогдсон хяналтын улсын байцаагч нарыг мэргэшил дээшлүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулах  | IV сард   | ЗТХЯ, МХЕГ, НТГ,<br>"АТҮТ" ТӨҮГ,<br>"УБТЗ" ХНН, "ЗТХТ"<br>ТӨҮГ |
| 2   | Далайн захиргаанаас жил бүр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулдаг "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" хамтарсан семинарт мэргэжлийн хяналтын улсын байцаагчдыг оролцуулах | VI сард   | ЗТХЯ, МХЕГ,<br>Далайн захиргаа                                 |
| <b>Б. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох</b> |  |           |  |
| 1   | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд санал өгөх /Мөсөн замын тээврийн хяналт/  | Тухай бүр | ЗТХЯ, МХЕГ   |
| 2   | Төмөр замын тээврийн хяналтын шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Засгийн газраар батлуулах   | IX сард   | ЗТХЯ, МХЕГ   |
| <b>В. Хяналт шалгалт</b>                            |  |           |  |
| <b>Автотээврийн чиглэлээр</b>                       |  |           |  |
| 1   | Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа эрхлэгч "Доктор авто сүлжээ" ХХК-ийн Яармаг дахь төвийн үйл ажиллагаанд шалгалт хийх                                    | II сард   | ЗТХЯ, НМХГ   |
| 2   | Хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын шатахууны чанарт шалгалт хийх   | IV сард   | ЗТХЯ, МХЕГ, НТГ  |
| 3   | Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхлэгч "Ертөнц тур" ХХК, "Дэлгэрэх хүнс" ХХК-нд шалгалт хийх /УБ хот/  | V сард    | ЗТХЯ, МХЕГ   |
| 4   | Сүхбаатар аймгийн Автотээврийн төв, хот хоорондын зорчигч тээвэр /1/, ачаа тээвэр /8/, авто-үйлчилгээ /5/ нийт 14 байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийх                              | VI сард   | ЗТХЯ, МХЕГ,<br>"АТҮТ" ТӨҮГ                                     |



|                                      |   |              |  |
|--------------------------------------|---|--------------|--|
| 5                                    | Хэнтий аймгийн Автотээврийн төв, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч "Эрчит хурдан хөлөг" ХХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийх   | VI сард      | ЗТХЯ, МХЕГ, "АТҮТ" ТӨҮГ  |
| 6                                    | Дорнод аймгийн Автотээврийн төв, ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч /4/ байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийх  | IX сард      | ЗТХЯ, МХЕГ, "АТҮТ" ТӨҮГ  |
| 7                                    | Улс, хот хоорондын зорчигч тээвэр /1/, ачаа тээвэр эрхлэгч /15/ байгууллагын үйл ажиллагаанд /Өмнөговь аймгийн Гурван тэс, Ноён сум/ шалгалт хийх   | III улиралд  | ЗТХЯ, МХЕГ, Орон нутгийн МХГ, АТҮТ" ТӨҮГ                                     |
| 8                                    | Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэгч иргэд, байгууллагуудын үйл ажиллагаанд шалгалт хийх  | IV улиралд   | ЗТХЯ, МХЕГ, НТГ, "АТҮТ" ТӨҮГ   |
| <b>Усан замын тээврийн чиглэлээр</b> |   |              |  |
| 9                                    | Хөвөлтийн улиралд усан замын тээврийн хэрэгслээр ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах   | VI-X сард    | ЗТХЯ-ны усан замын хяналтын байцаагч, орон нутгийн МХГ, ОБГ, Далайн захиргаа |
| 10                                   | Нуур, гол мөрөн хөлдөх, гэсэх үеэр ард иргэдийг техник хэрэгслээр мөсөн дээгүүр зорчуулахгүй байлгах, зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд аюулгүй байдлыг зохих ёсоор хангуулж, зорчуулах тухай албан бичгийг тухайн нуур, гол, мөрнийг нутаг дэвсгэртээ харьяалж буй аймаг, орон нутгийн удирдлагад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавих  | XI-V сард    | ЗТХЯ, МХЕГ, орон нутгийн МХГ   |
| 11                                   | "Мөсний баяр"-ын үеэр түүнд оролцогчдын аюулгүй байдлыг хангахад хяналт тавих, /мөсний баяр зохиогдох газрыг сонгох, тээврийн хэрэгсэл зорчих зам болон аялагчдын явах маршрутыг тогтоох, түүнд тэмдэг тэмдэглэгээ хийх, мөн аюултай бүсийг тогтоож анхааруулах тэмдэг, дарцагжуулах г.м/ оролцох   | III сард     | ЗТХЯ, МХЕГ, орон нутгийн МХГ   |
| <b>Автозамын чиглэлээр</b>           |   |              |  |
| 12                                   | Он дамжин хэрэгжиж буй болон шинээр баригдаж эхлэх авто зам, гүүр, замын байгууламжийн барилга, их засвар шинэчлэлт, засварын ажилд хяналт шалгалт хийх: Үүнд:<br>-Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто зам,<br>-Баянхонгор-Говь-Алтай чиглэлийн 126.7 км авто зам;<br>-Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртлэх 20,9 км замын өргөтгөл, шинэчлэл;<br>-Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замын төгсгөлөөс Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км авто зам;<br>-Баянхонгор – Арвайхээр чиглэлийн авто | I-VI улиралд | ЗТХЯ, МХЕГ, орон нутгийн МХГ-ын авто замын байцаагч нар                      |



|   |  |                |   |
|---|--|----------------|---|
|   | замын огцом эргэлтийг өөрчлөх Өлзийт сум сумын 4.4 км авто зам;<br>-Дорноговь аймгийн Алтанширээ сум Газрын тосны үйлдвэрийн тусгай зориулалтын 17.5 км хатуу хучилттай авто зам.  |                |   |
| 13  | Үргэлж байгаа объектуудад гүйцэтгэлийн шалгалт хийх:<br>-БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод баригдаж буй Туул гол дээрх Баянзүрхийн 288 у/м төмөрбетон гүүр;<br>-Сонсголонгийн 289.4 у/м төмөрбетон гүүр;<br>-Замын цагдаагийн газрын ойролцоох 267.7 у/м гүүрэн гарц;<br>-Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км авто зам;<br>-Улаанбаатар-шинэ нисэх чиглэлийн 32,2км хурдны авто зам;<br>-Тосонцэнгэл 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км;<br>-Наранбулаг-Хяргас нуурын зүүн хаяа-Сонгино чиглэлийн 135.5 км авто зам;<br>-Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замын ашиглалт, засвар арчлалт; | I-VI улиралд   | ЗТХЯ, МХЕГ, орон нутгийн МХГ-ын авто замын байцаагч нар |
| <b>Төмөр замын чиглэлээр</b>  |  |                |   |
| 14  | "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Дохиолол холбооны 2 дугаар ангид   | III сард       | ЗТХЯ, МХЕГ  |
| 15  | "Улаанбаатар төмөр зам" ХНН-т Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр  | I улиралд      | ЗТХЯ, МХЕГ  |
| <b>Г. Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх ажил, тандалт судалгааг зохион байгуулах</b> |  |                |   |
| <b>1. Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар</b>  |  |                |   |
| <b>Автотээврийн чиглэлээр</b>   |  |                |   |
| 1   | Зүүн аймгийн автотээврийн үйлчилгээ эрхлэгчдэд /Автотээврийн төв-3, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч-4, ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч-8, авто үйлчилгээний-8 байгууллагын 450 орчим хүн/ сургалт зохион байгуулах  | VI сард        | ЗТХЯ, МХЕГ, "АТҮТ" ТӨҮГ, орон нутгийн МХГ               |
| <b>Усан замын тээврийн чиглэлээр</b>  |  |                |   |
| 2   | Усан замын тээвэрлэлт эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид "Тээвэрлэлт эрхлэхэд тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангах" сэдэвт сургалт зохион байгуулах  | VI сард        | ЗТХЯ, МХЕГ, Далайн захиргаа орон нутгийн МХГ            |
| <b>Төмөр замын чиглэлээр</b>  |  |                |   |
| 3   | Төмөр замын тээврийн хяналтын шалгуур үзүүлэлтийг боловсруулахтай холбогдуулан төмөр замын тээврийн үйл ажиллагаанд тандалт судалгаа хийх  | II-III улиралд | ЗТХЯ, МХЕГ  |



## 2. Зөвлөн туслах үйлчилгээ

### Автотээврийн чиглэлээр

|   |  |         |   |
|---|--|---------|---|
| 1 | Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа эрхлэгч “Мөнх ерөөлт интернэйшнл” ХХК-ийн Налайх дахь төвийн үйл ажиллагаанд    | II сард | ЗТХЯ, МХЕГ                                      |
| 2 | Хэнтий аймгийн авто-үйлчилгээ эрхлэгч /4/ аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх   | VI сард | ЗТХЯ, МХЕГ                                      |
| 3 | Дорнод аймгийн хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч “АйС ВН” ХХК, “Тал нутгийн хэрлэн” ХХК-д зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | IX сард | ЗТХЯ, МХЕГ,<br>орон нутгийн МХГ,<br>“АТҮТ” ТӨҮГ |

### Авто замын чиглэлээр

|   |   |              |                                 |
|---|---|--------------|---------------------------------|
| 4 | Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн байнгын бэлэн байдал, ашиглалтын түвшин хангуулах, зам хариуцагч байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | I-IV улиралд | ЗТХЯ, МХЕГ,<br>Орон нутгийн МХГ |
|---|---|--------------|---------------------------------|

### Төмөр замын чиглэлээр

|   |   |            |  |
|---|---|------------|--|
| 5 | Дорноговь аймаг Айраг сумын нутагт буюу “УБТЗ” ХНН-ийн Замын 3 дугаар ангийн зам, гүүр инженерийн байгууламж хариуцсан ажилтан, албан хаагч нари сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | II улиралд |  |
|---|---|------------|--|

### Усан замын чиглэлээр

|   |   |              |   |
|---|---|--------------|---|
| 6 | Монгол Улсын Усан замын тээврийн тухай хуульд зааснаар усан замын тээврийн хэрэгслийн ээлжит техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж явуулах | VI-VIII сард | ЗТХЯ, МХЕГ,<br>Далайн захиргаа,<br>Орон нутгийн ОБГ,<br>БОАЖГ |
|---|---|--------------|---|

## 4. Урьдчилан сэргийлэх шалгалт

### Автотээврийн чиглэлээр


|   |   |         |            |
|---|---|---------|------------|
| 1 | Хотын доторх болон хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч “Тэнүүн огоо” ХХК, “Хараацайн жигүүр” ХХК-ийн үйл ажиллагаанд | II сард | ЗТХЯ, МХЕГ |
|---|---|---------|------------|

### Автозамын чиглэлээр

|   |   |                |   |
|---|---|----------------|---|
| 2 | Улсын чанартай зам, зам байгууламжийн бэлэн байдал, ашиглалтын бэлэн байдлын түвшинд урьдчилан хяналт шалгалт хийх, /Зам хариуцагч ТӨХК 10, хувийн хэвшлийн 5 аж ахуйн нэгж хамрагдана/   | I-IV улиралд   | ЗТХЯ, МХЕГ  |
| 3 | Авто зам, замын байгууламжийн хөлдөлт, гэсэлтийн үед даац хэтрүүлэн зорчиж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, зөрчлийг арилгуулах замаар мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтын хийж, холбогдох шийдвэрийг гарган, зөвлөмж хүргүүлэх | II-III улиралд | ЗТХЯ, МХЕГ,<br>“ЗТХТ” ТӨҮГ,<br>“АТҮТ” ТӨҮГ, орон<br>нутгийн МХГ |

|   |  |                   |            |
|---|--|-------------------|------------|
| 4 | -Өмнөговь аймгийн Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн 43 км хатуу хучилттай авто замын ашиглалт, засвар арчлалтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | II-III<br>улиралд | ЗТХЯ, МХЕГ |
|---|--|-------------------|------------|

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭНХБОЛД

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД  
БҮТЦИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА



Д.ЖАРГАЛ